

БАТЛАВ.
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР

З.БААСАННЯМ

АЖЛЫН ДААЛГАВАР

2026.04.24

Улаанбаатар хот

Үйлчилгээний ажлын
зорилго:

Төрийн байгууллагын үйл ажиллагаанд гэнэтийн, урьдчилан таамаглахад төвөгтэй гадаад, дотоод хүчин зүйлээс шалтгаалсан нөхцөл байдал үүсэхэд шийдвэр, үйл ажиллагааны хэвийн горим алдагдаж, хяналт, зохицуулалт сулрахтай холбоотойгоор авлига үүсэх эрсдэлийг урьдчилан илрүүлэх, тодорхойлох, үнэлэх, улмаар сэргийлэхэд ашиглах аргачлалыг олон улсын сайн туршлага, жишиг загварт нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай арга зүй, хэрэгслийн хамт захиалагчид хүлээлгэн өгөхөд оршино.

Хугацаа:

Хуанлийн 150 хоног

Эхлэх хугацаа:

2026 оны 05 дугаар сарын 25-ны өдөр

Дуусах хугацаа:

2026 оны 10 дугаар сарын 22-ны өдөр

Байршил:

Авлигатай тэмцэх газар

Үнэлгээний Зорилго	Ирээдүйд үүсч болзошгүй, урьдчилан таамаглахад төвөгтэй нөхцөл байдалд үүсэх авлигын эрсдэлийг урьдчилан илрүүлэх, тодорхойлох, шинжлэх, үнэлэх аргачлалыг олон улсын сайн туршлага, жишиг загварт нийцүүлэн, байгууллагын онцлогт тулгуурлан боловсруулж, нэвтрүүлэхэд оршино. Энэхүү аргачлал нь гэнэтийн нөхцөлд хяналт, зохицуулалт алдагдсанаас үүдэх авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэхэд чиглэнэ.
Үндэслэл	Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 10.3.1-д “Ирээдүйд тулгарч болзошгүй авлигын эрсдэл бүхий нөхцөл байдлыг үнэлэх аргачлалыг боловсруулж, бэлэн байдлыг хангаж эрсдэлээс урьдчилан сэргийлнэ” гэж, 2024 оны 46 дугаар тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 10.3.1.1-д “Ирээдүйд тулгарч болзошгүй авлигын эрсдэл бүхий нөхцөл байдлыг үнэлэх аргачлалыг боловсруулах, бэлэн байдлыг хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ” авахаар заасан.
Хамрах хүрээ	Гүйцэтгэгч нь хамрах хүрээг захиалагчтай зөвшилцөн тогтооно. Аргачлал нь байгууллагын үйл ажиллагаа, шийдвэр гаргалтын үйл явц, оролцогч талууд, хяналт, зохицуулалтын механизм, түүнчлэн гадаад орчны нөлөөллийг цогцоор нь тусгасан байна.
Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Гүйцэтгэгч нь ажлын зорилгын хүрээнд дараах зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд: - Ажлын үе шат, хугацаа, гүйцэтгэлийн дарааллыг тусгасан календарчилсан төлөвлөгөөг боловсруулж, захиалагчаар батлуулах;

	<ul style="list-style-type: none"> - Ирээдүйд үүсч болзошгүй авлигын эрсдэл бүхий нөхцөл байдлыг үнэлэх аргачлал боловсруулахад шаардлагатай урьдчилсан судалгаа хийж, байгууллага салбарын бүтэц, чиг үүрэг, үйл ажиллагаа, шийдвэр гаргалтын процесс, хяналтын механизмд дүн шинжилгээ хийх, мөн гадаад, дотоодын ижил төстэй арга зүй, сайн туршлагыг судалж, Монгол Улсын нөхцөлд нийцүүлэх боломжийг тодорхойлох; - Урьдчилсан судалгаанд үндэслэн аргачлалын зорилго, хамрах хүрээ, агуулга, бүтэц, хэлбэр, нэр томьёо, хамрах салбар, үйл ажиллагаа, оролцогч талууд, эрх зүйн үндэслэлийг нарийвчлан тодорхойлох; - Ирээдүйд үүсч болзошгүй, урьдчилан таамаглахад төвөгтэй нөхцөл байдалд үүсэх авлигын эрсдэлийг урьдчилан илрүүлэх, тодорхойлох, шинжлэх, үнэлэх нэгдсэн аргачлал, түүний загвар, шалгуур үзүүлэлт, үнэлгээний арга зүйг боловсруулах; - Эрсдэлийг тодорхойлох, шинжлэх, үнэлэхэд ашиглах арга хэрэгсэл (шалгуур, маягт, асуумж, үнэлгээний загвар, заавар)-ийг боловсруулах; - Аргачлалыг хэрэгжүүлэх гарын авлага, зааварчилгааны төслийг боловсруулж, практикт хэрэглэх боломжийг хангах; - Аргачлалын төслийг холбогдох талуудаар хэлэлцүүлэх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа болон бусад сонирхогч талуудын санал авах ажлыг зохион байгуулж, тусган сайжруулах; - Боловсруулсан аргачлалыг сонгосон байгууллага, салбар, эсхүл үйл ажиллагаанд туршилтын байдлаар хэрэглэж, үр дүнд үндэслэн сайжруулалт хийх; - Ажлын явц, үр дүнг захиалагчид үе шаттай танилцуулж, санал, зөвлөмжийг тусган эцэслэх; - Үнэлгээ, судалгааны явцад цуглуулсан цаасан болон цахим мэдээллийн сан, баримт бичгийг захиалагчид хүлээлгэн өгөх.
Үнэлгээний мэдээлэл цуглуулалт	Гүйцэтгэгч нь аргачлал боловсруулахад шаардлагатай мэдээллийг баримт бичгийн шинжилгээ, ярилцлага, асуумж болон бусад эх сурвалжаас цуглуулж, судалгаанд ашиглана.
Удирдлага зохион байгуулалт	Гүйцэтгэгч нь Авлигатай тэмцэх газрын холбогдох нэгжтэй нягт хамтран ажиллаж, ажлын явц, гүйцэтгэлийг тухай бүр тайлагнана.
Тайлангийн хуваарь	Гэрээ байгуулж ажил эхэлснээс хойш долоо хоног тутамд ажлын явцын тайланг захиалагчид танилцуулна.
Хүлээгдэж буй үр дүн, бүтээгдэхүүн	Ирээдүйд үүсч болзошгүй авлигын эрсдэл бүхий нөхцөл байдлыг үнэлэх нэгдсэн аргачлал, түүнийг хэрэгжүүлэх гарын авлага, зааварчилгаа, мөн дагалдах үнэлгээний маягт, асуумж, шалгуур үзүүлэлт, загвар, хэрэгслүүдийг боловсруулж, иж бүрнээр нь захиалагчид хүлээлгэн өгнө.
Төлбөрийн нөхцөл	Ажлын хөлсийг гэрээнд заасны дагуу төлнө. Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд холбогдох бүх зардал, татвар зэрэг багтсан байна.
Баталгаат хугацаа	Аргачлалыг хүлээлгэн өгсөн өдрөөс хойш 2 сарын хугацаанд зөвлөгөө, тодруулга өгөх байдлаар баталгаат үйлчилгээ үзүүлнэ.

ТЕХНИКИЙН ЧАДАВХ БОЛОН ТУРШЛАГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

№	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан туршлага	Мэргэжил
1	Төслийн удирдагч	1	<ul style="list-style-type: none"> - Эрсдэлийн үнэлгээ, бодлогын шинжилгээ, аргачлал боловсруулах чиглэлээр 5-аас доошгүй жил, үүнээс авлигын эрсдэлийн үнэлгээ, байгууллагын шударга байдлын үнэлгээ эсхүл түүнтэй адилтгах чиглэлээр 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх; - Судалгаа, шинжилгээ болон аргачлал боловсруулах ажлыг удирдан зохион байгуулж байсан; - Үнэлгээний аргачлал, шалгуур үзүүлэлт, эрсдэлийн матриц, зураглал, загвар боловсруулах, тайлан, дүгнэлт боловсруулах өндөр чадамжтай байх; 	Эрх зүй, төрийн болон нийтийн удирдлага, засаглал, авлигын эсрэг бодлого, эдийн засаг, боловсрол судлалын чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй
2	Судлаач, шинжээч	1	<ul style="list-style-type: none"> - Эрсдэлийн үнэлгээ, бодлогын дүн шинжилгээ, хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал боловсруулах чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх; - Эрсдэлийн хүчин зүйл тодорхойлох, процессын шинжилгээ хийх, үнэлгээний шалгуур, үзүүлэлт боловсруулах, чанарын болон тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх ур чадвартай байх; 	Нийгмийн шинжлэх ухаан, эдийн засаг, эрх зүй, төрийн удирдлагын чиглэлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй
3	Мэдээлэл, арга зүйн шинжилгээ хариуцсан мэргэжилтэн	1	<ul style="list-style-type: none"> - Судалгаа, мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх; - Аргачлал боловсруулахад шаардлагатай өгөгдлийн бүтэц, үзүүлэлт, хэмжүүр боловсруулах, мэдээлэл нэгтгэх, дүн шинжилгээ хийх чадвартай байх; судалгааны ёс зүй, мэдээллийн нууцлалын зарчмыг мөрдөн ажиллах чадамжтай байх; 	Эдийн засаг, статистик, социологи, дата шинжилгээ, бизнесийн удирдлагын чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй
4	Аргачлал турших зохицуулагч	1	<ul style="list-style-type: none"> - Судалгаа, шинжилгээ болон аргачлал турших ажлыг зохион байгуулах чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх; - Аргачлалын туршилтыг зохион байгуулах, оролцогч талуудтай хамтран ажиллах, туршилтын явцад гарсан үр дүнг нэгтгэх, санал, сайжруулалтыг боловсруулах чадвартай байх; 	Дээд боловсролтой, судалгааны зохион байгуулалт, ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах туршлагатай